

**МОНГОЛ ГЕРМАНЫ ХАМТАРСАН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ  
АМЖИЛТТАЙ БОЛЛОО**

Шинжлэх Ухааны Академийн Олон Улс Судлалын хүрээлэнгийн дэргэдэх Монголын Герман Судлал төв, Монгол Улс дахь ХБНГУ-ын Элчин сайдын яам, Стратегийн судалгааны хүрээлэн, Конрад Аденауэр сан хамтран “Герман, Монголын харилцаа – өнөөгийн байдал ба хэтийн төлөв” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2013 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Гадаад Хэргийн Яамны хурлын их танхимд амжилттай зохион байгууллаа.

Монгол, Германы Гадаад харилцааны сайд нар мэндчилгээ ирүүлсэн уг бага хурлыг ХБНГУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд, ноён Др.Шаллер нээсэн бөгөөд УИХ-ын эрхэм гишүүн М.Батчимэг болон Гадаад харилцааны яамны дипломатууд, эрдэмтэн судлаачид, албаны бусад хүмүүс оролцсон байна.

Тус хүрээлэнгийн захирал, доктор Д. Шүрхүү “Бодит мэдээлэл – Түншлэл амжилтанд хүрэх тулгуур үндэс” гэсэн сэдвээр тавьсан илтгэлдээ Германы Монгол судлалын институтууд, Германыг судалдаг Монголын судалгааны институтууд чамлахаар түвшинд байгааг хөндсөн байна. Герман улсын Улс төр цэргийн нийгэмлэгийн тэргүүн ноён Р.Тийле “Монгол Улс аюулгүй байдлаа хангах гол суурь нь хоёр хөрш оронтойгоо зөв нарийн суурь бодлоготойгоор харьцах шаардлагатай. Үүнээс гадна аюулгүй байдал, эрх чөлөөг хангахын тулд зайлшгүй олон улсын төвшинд гуравдагч хөрш орнуудтай хамтран ажиллах ёстой хэмээлээ.

Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллагын Улаанбаатар дах суурин төлөөлөгчийн газрын захирал З.Мюллер “70 мянган албан хаагчтай аж ахуй нэгж маань Монгол Улсад маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд Монгол Улс эрчимтэй өөрчлөгдөж байгааг илэнхийлэв. Стратегийн хүрээлэнгийн захирал Д.Ганбат “Гуравдагч хөршийн бодлого тодорхой хэмжээнд амжилтанд хүрсэн тул үүнийг дүгнэх цаг ирсэн. Мэдээж хэрэг үүнд хүрэхийн тулд амар дардан зам туулаагүй. Богд хаант засгийн үед, Ардын засгийн үед алинд нь ч Герман улс руу нот бичиг явуулж байсан. Зүүн Германтай харилцаа тогтоогоод 70 жилийн нүүр үзсэн бол баруун Германтай 40 жил болж байна. Гэхдээ одоо Монгол Улс хараад суух биш өөрийгөө сорьж үзэх цаг болсон.

Сүүлийн хэдэн зуун жилийн турш дандаа хүний үг, заавраар явж ирсэн. Одоо манай улс жижиг гэж хэлэгддэг үе ард үлдсэн. Нэгэнт тусгаар тогтносон улс юм чинь бүс нутгийн хэмжээнд оролцогч, санаачлагч байх үе ирсэн. Эдийн засаг, байгалийн нөөцийн хувьд яавч жижиг улс байхаа больсон” хэмээн ярилаа.

Түүнчлэн Герман, Монголын түүхий эдийн түншлэл, гуравдагч хөршийн бодлого, эрх зүйн салбарын өөрчлөлт, археологийн судалгаа зэрэг олон сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн байна. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд монгол, герман хэлээр хэвлэгдэн олон удахгүй нийтийн хүртээл болно.

З. Батчимэг